

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 -р сарын 18-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9.6.18 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.16 дахь заалт, болон “Ногдол ашгийн бодлого”-ын 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 1,793,197,950 (нэг тэрбум долоон зуун ерөн гурван сая нэг зуун ерөн долоон мянга есөн зуун тавин) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай;
2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 25 (хорин таван) төгрөгөөр тогтоосугай;
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай;
4. Энэхүү тогтоолын 2-т заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай;
5. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

